

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны цахим сургалт

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах шаардлагыг хангасан байна:”, 5.1.2-т ” энэ хуулийн 8.1-д заасан Мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын сургалтад хамрагдсан байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд болон түүний холбогдох ажилтан мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх сургалтад хамрагдах үүрэгтэй.” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, менежер, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэдийг дээрх сургалтад цахимаар оролцож, гэрчилгээ авах боломжийг бүрдүүллээ.

Иймд дээрх сургалтад хамрагдах бол [энд дарж](#) бүртгүүлнэ үү.

Жич: Сургалтад хамрагдахдаа ажлын өдрүүдэд ажлын цагаар бүртгүүлж нэвтрэх нэр, нууц үгээ авах боломжтой бөгөөд хичээлийн хөтөлбөрийг 72 цагийн дотор (3 хоног) судалж, шалгалтаа өгөн гэрчилгээгээ татан авч бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтад хавсаргана уу.

Холбоо барих:

Сургалтын бүртгэл, бусад сургалттай холбоотой асуудлаар Санхүүгийн боловсролын HUB сургалтын төвтэй **99070707** утсаар холбогдоно уу.